БАТЛАВ. ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН / ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЕОЛОГИ СУДАЛГААНЫ АЖЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН/ БЭЛТГЭХЭД МӨРДӨГДӨХ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

20.... оны .... -р сарын .... -ны өдөр Дугаар: .... Улаанбаатар хот

№	АГУУЛГА	
1.	**Зөвлөх үйлчилгээний нэр**	"Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын санхүүгийн нэгтгэсэн тайлан /хөрөнгө оруулалт, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх геологи судалгааны ажлын санхүүгийн тайлан/ бэлтгэхэд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах зөвлөх үйлчилгээ"
2.	**Захиалагч газар, хэлтсийн нэр**	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн захиргааны удирдлагын газрын санхүүгийн хэлтэс
3.	**Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх хугацаа**	Хугацаа: 3 сар Эхлэх: 2021 оны 2 дугаар сарын 24-ны өдөр Дуусах: 2021 оны 5 дугаар сарын 24-ны өдөр
4.	**Зөвлөх үйлчилгээний үндэслэл, хэрэгцээ шаардлага**	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт болон Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандартыг (СТОУС болон НББОУС), Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС) тус тус судалж, практикт нэвтрүүлэх; Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 16.1, 17.2, 19.1.1 заалтууд, 26 дугаар зүйлийн 26.1-26.3 заалтууд, 56 дугаар зүйлийн 54.2 заалтуудыг тус тус хэрэгжүүлэх; Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 8.9.5, 8.9.8 заалтуудыг хэрэгжүүлэх; Төрийн аудит болон санхүүгийн хяналтын байгууллага зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах; Сайдын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдэх байгууллагуудын тайланг нийцүүлэх; Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал шийдвэр, журмуудад нийцүүлэх; Сайдын багцын хөрөнгө оруулалт, геологи судалгааны ажлын хэмжээ нэмэгдэж байгаа, геологи судалгааны ажлын бүртгэлийн онцлог шинж байдлыг олон улсын нягтлан бодох бүртгэлд нийцүүлэх;
5.	**Судалгааны зорилго**	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын зорилго нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн журам, зааврын дагуу хөрөнгө оруулалт, геологи судалгааны ажлын

		санхүүгийн тайлан гаргах, сайдын багцын нэгтгэсэн тайлан бэлтгэхэд хэрэглэх зарчим, горимыг тогтоож өгөхөд оршино.
6.	**Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн хамрах хүрээ, үйлчлэх хугацаа**	Энэхүү баримт бичгийг Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын санхүүгийн тайланг бэлтгэх болон сайдын багцын нэгтгэл хийх, нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх, хөрөнгө оруулалт, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх геологи судалгааны ажлын үйл явцыг гүйцэтгэхэд мөрдөнө. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны талаар харилцагч, хэрэглэгч нарт толилуулж байгаа албан ёсны мэдээлэл, санхүүгийн тайлан, тэдгээрийн хавсралт, тодруулга нь энэхүү бодлогын шаардлагад нийцсэн байна. Бүртгэлийн бодлогын баримт бичгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.
7.	**Нягтлан бодох бүртгэлийн бодлогын агуулга**	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын тухай "УСНББОУС-8"-д: "Нягтлан бодох бүртгэлийн бодлого гэдэг нь санхүүгийн тайланг бэлтгэх болон толилуулахад мөрддөг аж ахуйн нэгжийн гаргасан тусгай зарчим, суурь, дүрэм, журам ба практик үйл ажиллагаа юм. " гэж тодорхойлсон. Энэ агуулгын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, хөрөнгө оруулалт, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх геологи судалгааны ажлын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөх дараах зүйлд анхаарал хандуулна. 1. Яамны үйл ажиллагаанд мөрдөх мөрдөх бүртгэлийн зарчмуудыг тогтоож өгөх; 2. Яамны санхүүгийн нэгтгэсэн тайланг аккруэл сууриар бэлтгэх; 3. Яамны үйл ажиллгаанд мөрдөх бизнесийн хуулиуд болон УСНББОУС -ын хэргэлээг тогтоох; 4. Яамны үйл ажиллагаанд мөрдөж байгаа бүх дүрмийг судалж нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй уялдуулах; 5. Яамны үйл ажиллагаанд мөрдөж байгаа бүх дүрмийг судалж шаардлагатай бол нэмэлт сайжруулалт хийх; 6. Төсөв санхүү, өмч хөрөнгөтэй холбоотой шинээр өөрчлөгдсөн хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, журам, дүрэм заавар,

		аргачлалуудын агуулга, үзэл санаа, салбарын онцлогийг судлах; 7. Яамны бүртгэлийн үйл ажиллагааг газар дээр нь судалж холбогдох албан тушаалтантай уулзаж яамны онцлогт тохирсон практик хэрэглээнд (хүлээн зөвшөөрөх, уулын үйлдвэрийн зардал бүртгэж өртөг тооцох, элэгдэл тооцох, хөрөнгийг капиталжуулах, бодит үнэ цэнэ тогтоох, найдваргүй авлагын хасалдуулга тооцох, татварын зөрүүгийн тооцоо хийх, валютын ханшийн өөрчлөлт тооцох гэх мэт) анхаарч нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгана. 8. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын бүх хөрөнгө, эх үүсвэр, өр төлбөрийг УСНББОУС-ын дагуу нэгтгэж, санхүүгийн болон төсвийн нэгтгэсэн тайланг бэлтгэх аргачлалыг боловсруулах; 9. Төрийн сангийн заасан журам, дүрэм,Төсвийн хуулийн дагуу НББ-ийн бодлогын баримт бичигт тусгах,
8.	**Санал болгож буй арга зүй**	Мэдээлэл цуглуулах-боловсруулах-дүн шинжилгээ хийх-дүгнэлт гаргах-санал боловсруулах
9.	**Нягтлан бодох бүртгэлийн бодлого, гормын бүтэц**	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн ерөнхий бүтэц, зохион байгуулалт дараах байдалтай байна. Үүнд: **Нэг. Ерөнхий зүйл** • Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийн үндэслэл • Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийн зориулалт хамрах хүрээ • Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийн мөрдөлт **Хоёр. Нягтлан бодох бүртгэлийн зохион байгуулалт** • Санхүүгийн тайлан бэлтгэхэд мөрдөх стандарт заавар, журам • Санхүүгийн тайлагналын мөнгөн хэмжүүр • Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ • Санхүүгийн болон төсвийн жил • Тайлангийн цаглабар **Гурав. Нягтлан бодох бүртгэлийн ерөнхий бодлого** *Санхүүгийн тайлангийн толилуулга* • УСНББОУС 1 Санхүүгийн Тайлангийн Толилуулга • УСНББОУС 2 Мөнгөн Гүйлгээний Тайлан • УСНББОУС 14 Тайлагналын Үеийн Дараах Үйл Явдал • УСНББОУС 18 Сегментийн Тайлагнал • УСНББОУС 20 Холбоотой Талуудын Тодруулга • УСНББОУС 24 Санхүүгийн Тайлан Дахь Төсвийн Мэдээллийн Толилуулга

		Дээрх УСНББОУС-д нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн ерөнхий бодлогыг дараах байдлаар тодорхойлно. • Санхүүгийн тайлангийн зорилго • Санхүүгийн тайлан бэлтгэх зарчмууд • Санхүүгийн тайлангийн элементүүдийг хүлээн зөвшөөрөх ерөнхий зарчим • Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн **Дөрөв. Нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлого, горимууд** *Орлого болон зардлын бүртгэл* • УСНББОУС 9 Арилжааны ажил гүйлгээний орлого • УСНББОУС 23 Арилжааны бус ажил гүйлгээний орлого *Хөрөнгийн бүртгэл* • УСНББОУС 5 Зээлийн Өртөг • УСНББОУС 12 Бараа Материал • УСНББОУС 17 Үндсэн Хөрөнгө • УСНББОУС 21 Мөнгө үл бий болгогч хөрөнгийн үнэ цэний бууралт • УСНББОУС 26 Мөнгө бий болгогч хөрөнгийн үнэ цэний бууралт • УСНББОУС 31 Биет Бус Хөрөнгө *Санхүүгийн хэрэглүүр* • УСНББОУС 28 Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга • УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт • УСНББОУС 30 Санхүүгийн хэрэглүүр *Өр төлбөр* • УСНББОУС 19 Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө • УСНББОУС 39 Ажилчдын Тэтгэвэр, Тэтгэмж **Тав. Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нэгтгэл** • УСНББОУС 34 Тусдаа Санхүүгийн Тайлан • УСНББОУС 35 Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан • УСНББОУС 36 Хараат Компани болон Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт • УСНББОУС 37 Хамтын Хэлэлцээр • УСНББОУС 38 Бусад Байгууллага дах Хувь Оролцооны Тодруулга • УСНББОУС 40 Улсын Секторын Нэгдэл (Бизнесийн Нэгдэл) **Зургаа. Хавсралт** • Холбогдох заавар, журам
10.	**Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг**	1. УСНББОУС 2. СТОУС, НББОУС 3. Төсвийн тухай хууль 4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 5. Төсвийн тухай хууль

	боловсруулахад ашиглах материал	6. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 7. Төрийн албаны тухай хууль 8. Хөдөлмөрийн тухай хууль 9. Архивын тухай хууль 10. Ашигт малтмалын тухай хууль 11. Татварын болон багц хуулиуд 12. Үнэт цаасны тухай хууль 13. Татварын багц хууль 14. Төрийн хяналт шалгалтын тухай хууль 15. Аудитын тухай хууль 16. Засгийн газрын тогтоол, сангийн сайдын тушаалууд 17. УУХҮЯ-аас гарсан тушаал, шийдвэр, журмууд
11.	**Судалгааны тайлангийн үе шат**	**Эхлэлтийн тайлан**: Түүвэр сонгох стратеги, мэдээлэл цуглуулах арга, нарийвчилсан ажлын төлөвлөгөөний дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хөрөнгө оруулалт, геологийн судалгааны ажлын санхүүгийн тайлан бэлтгэхтэй холбоотой одоогийн хууль эрх зүйн зохицуулалт болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй заавар, журмууд нь УСНББОУС-д нийцсэн байдлын судалгааны тайлан. Гэрээ байгуулагдсанаас 30 хоногийн дотор
		Урьдчилсан тайлан: Урьдчилсан тайлан нь арга зүй, үр дүн, дүгнэлт, санал зөвлөмж зэргийг багтаасан 30 хуудсаас хэтрэхгүй хэмжээтэй байна. (Тайлангийн ерөнхий бүтцийг нарийвчилсан удирдамжийн бүлэг 3-аас харна уу). Гэрээ байгуулагдсанаас 2 сарын дотор Урьдчилсан тайланд захиалагч байгууллагын саналыг авч, сайжруулах ажил гүйцэтгэнэ.
		Эцсийн тайлан: Захиалагч байгууллагаас авсан саналыг тусган тайланг эцэслэж, хэвлэмэл болон файл хэлбэрээр хүлээлгэж өгнө. Гэрээний хугацаа дуусахаас өмнө.
12.	**Хүлээгдэж буй үр дүн**	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, хөрөнгө оруулалт, геологийн судалгааны ажлын санхүүгийн тайлан бэлтгэхтэй холбоотой одоогийн хууль эрх зүйн зохицуулалт болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй заавар, журмууд нь УСНББОУС-д нийцсэн байдлын судалгааны тайлан. Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн заавар, журам болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад нийцсэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, хөрөнгө оруулалт, геологийн судалгааны ажлын санхүүгийн тайлан бэлтгэх, нэгтгэхэд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг. Нягтлан бодох бүртгэлийн болон Засгийн газрын нэгтгэсэн тайлан бэлтгэх арга зүйтэй нягт уялдсан байх. Геологийн судалгааны ажлын төслүүдийн тайланг бүртгэлд тусгах, капиталжуулах, элэгдүүлэх, данснаас хасах, шилжүүлэх журналын бичилтүүд тодорхой болсон байх. Геологи судалгааны ажлыг төлөвлөх, тайлан хүлээн авах, гэрээ дүгнэх, санхүүжилтийн хүсэлт илгээх, санхүүжүүлэх, гүйцэтгэлийн баталгаа бууруулах, цуцлах үе шатууд тодорхой болсон байх.

		Сайдын багцын байгууллагуудын хоорондын тооцооны устгах бичилтүүдийн журналын бичилтүүд тодорхой болсон байх. Сангийн яам болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас гаргасан тушаал шийдвэртэй нийцсэн байх. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг 2 хувь файлаар болон товхимол хэлбэрээр бэлтгэгдсэн байх.